

Монголын түүхийн үечлэлийн асуудалд

Д.Энхцэцэг

Монгол улсын их сургууль. Нийгмийн шинжлэх ухааны сургууль. Түүхийн тэнхим

Өгүүллийн товч утга: Энэхүү өгүүлэлд Монгол улсын түүхийн нэгэн зурвас үеийн талаархи олон янзын ойлголтыг харьцуулан, ямар нэг шинэ содон томъёолол, улс төрийн үйл явцаас улбаалан нэрлэх нь төдий л зохимжтой бус тул Монгол улсын түүхийн ерөнхий үечлэлд хамааруулан, цаг хугацааны хязгаартайгаар ойлгох нь зүйтэй гэсэн санаа дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: “Эзэнт гүрний дараахь үе”, “Монголын төрийн бутралын үе”, “Мин улсаас ван өргөмжилж зассан үе”, “Самуурлын үе”, “Умард (ар, хойд) Юаны үе”, “После Юаньский период”, “Бага хаадын үе”

Монгол улсын түүхийн судалгаанд шинэ, шинэ гаргалгаа дүгнэлт хийх нь түүхчдийн үүрэг агаад улс үндэстнийхээ тусгаар тогтнол бүрэн бүтэн байдлыг бататган хөгжүүлэх, үндэсний язгуур эрх ашигт бүрэн нийцэхийн хамт даяаршлын давалгаа улам бүр эрч хүчээ авч буй энэ цаг үед иргэддээ эх оронч, улс үндсээ бадраах үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх явдал бол өнөөгийн нийгмийн захиалгаар нөхцөлдсөн үйл явц юм.

Сүүлийн арав гаруй жилд Монголын түүхийн судалгаанд эргэлт гарч, хурдацтай өөрчлөлт хийн олон асуудлыг шинээр авч үзэх болсон хэдий ч судлаачдын анхаарлыг татаж байгаа боловч олон асуудлыг нягтлан, түүхийн ээдрээтэй асуудалд хариулт өгөх шаардлага хэвээр байна. Үүний нэг илрэл нь “*Монголын түүхийн үечлэлийн асуудал*”-д анхаарал хандуулж буй явдал юм. Түүхийн үечлэлийн асуудал нийгэм түүхийн судалгааны гол цөм бөгөөд судлаачид олон янзын хувилбарыг дэвшүүлэн тавьж ирсэн нь хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн нийтлэг талыг харгалзан үзэхийн хамт аливаа улс орны онцлогийг тусгах зарчимд нийцдэг бололтой.

XIV зууны II хагасаас Хятад дахь Юань улсын ноёрхол халагдан, хаант төр уугуул нутагтаа шилжин, хөрш улс түмнүүдтэйгээ хил залган орших болсноор манай Монгол улсын түүхийн нэг үе эхэлдэг гэж үздэг. Монголчууд хүчирхэгжин дэлхийн түүхийг идэвхитэй бүтээлцсэн цаг үе нэгэнт ард хоцорч, төр улсыг удирдах эзэн хааны хүч чадал засаглах чадвар, эрх мэдэл нэр хүнд суларч, томоохон язгууртан ноёдын эдийн засаг, цэрэг улс төрийн бие даасан байдал бэхжин дотоодын зөрчил тэмцэл хурцдан, нэгдмэл хүчирхэг байдал улирч энэ бүхэн нь улс орны үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, төрийн тусгаар тогтнол алдагдахад хүрсэн нь тухайн үеийн түүхийг гол онцлог байв. “Сайн нь миний багш сайн бус нь бас ч миний багш болой” хэмээх мэргэдийн сургаалиар хүчирхэг мандсан үе бидний түүх, задарч бутран хүчин мөхөсдсөн нь ч бас бидний түүх болохоор дурьдан буй үеийн алдаа оноо бүхэн эрт эдүгээгийн монголчуудын түүхтэй амин холбоотой билээ. Монголын түүхийн бусад үетэй харьцуулбал судалгаа харьцангуй бага, өөр өөр өнцгөөс харсан судалгаанд дулдуйдсан ч тал байгаа болохоор үндэсний түүхээ туурвихдаа “өөрөөрөө” төвлөн, улс үндэснийхээ эрх ашгийг дээдлэх үүднээс анхаарал хандуулан судлах нь зайлашгүй чухал юм.

Бидний судлагдхуун болгон авч үзэж буй түүхэн үйл явцын *цаг хугацааны хамрах хүрээний талаар* “XIV зууны II хагасаас XVII зууны тэргүүн хагасын үеийн монголын түүх”, “Феодалын бутралын үе”, “Монголын төрийн бутралын үе”, “Монголын төрийн төв эх нутагтаа төвлөсөн үе”, “Эзэнт гүрний дараахь үе”, “Их гүрний хойших үе”, “Мин улсаас ван өргөмжилж зассан үе”, “Самуурлын үе”, “Мингийн үеийн Монгол”, “Умард (ар, хойд) Юаны үе”, “После Юаньский период”, “Бага хаадын үе” гэж олон янзаар тэмдэглэж ирсэн.

I. МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАД ҮЕИЙН АСУУДАЛ

Аливаа ард түмний түүхийн ерөнхий үечлэлд төр-улс, газар нутаг, түүхэн цаг үеийн онцлог, цаг хугацааны шинжтэй ойлголтуудыг нэгдмэл байдлаар бие биетэй нь нөхцөлдүүлэн авч үздэг болохоор *бид*, Монгол улсын түүхийн нэгэн үе, хэдийгээр улсын нэрийн тухайд олон янзаар томъёолон ямар нэг шинэ содон томъёолол, улс төрийн үйл явцаас улбаалан нэрлэх нь төдий л зохимжтой бус тул Монгол улсын түүхийн ерөнхий үечлэлд хамааруулан, цаг хугацааны хязгаартайгаар ойлгох нь зүйтэй гэж бодож байна.

Туурга тусгаар Монгол улсын хил хязгаар нутаг дэвсгэрийн хамарч байсан хүрээг харгалзах, түүхийг эдүгээчлэн үзэх ялангуяа тухайн үеийн Монголын түүхийг одоогийн ойлголтоор ӨМӨЗО, Шинжаан Уйгарын өөртөө засах орон, ОХУ-ын Буриад, Алтайн хязгаар, манай Монгол улсын нутаг гэж тус тус саланги тусгаар байдлаар авч үзэх боломжгүй. Тэр үед *Монгол нэрт нэг улсын* хүрээнд багтаж байсныг харгалзан үзэх нь арга зүйн хувьд зүйтэй юм.

Цаг хугацааны хувьд XIV зууны II хагасаас (1368 он) тухайн үеийн түүх эхэлдгийг нэгэн адил хүлээн зөвшөөрдөг. Харин хэдий хүртэл үргэлжилсэн болох талаар нэгдмэл бус ойлголт уламжлагдан иржээ. Үүнд:

*Нэгдүгээрт. Монгол улсын түүх (XIV зууны II хагасаас XVII зууны тэргүүн хагас)*¹ гэж үзэх нь их төлөв Алтан урагт Лигдэн хутагт хаан 1634 онд нас нөгчин, 1636 онд өмнөд Монголын олон аймаг Манжид эзлэгдсэнтэй холбоотой Хятад дахь монголын түүхийн судалгаа, өнөөгийн ӨМӨЗО-ны түүхчдийн бүтээлүүдэд баримталж буй чиг хандлага юм. 1636 оноос өмнөд Монгол Манж улсын улмаар ДИУ, БНХАУ-ын бүрэлдхүүнд багтах болсон тул хятадын түүхийн уламжлалт Династийн үечлэлийн дагуу энэ үеийг Мин (1368-1644), Чин (1616-1911) династийн түүхэнд хамааруулан ойлгодогтой шууд холбоотой. Хятад дахь энэ үечлэл дэлхийн бусад орон дахь (Орос, Япон, Солонгос, АНУ зэрэг) тухайн үеийн монголын түүхийн судалгаанд уламжлагдан ирсэн. Өмнөд Монгол Манжид эзлэгдсэнээр Монгол улс, Монгол төр мөхсөн гэвэл дэндүү ташаа зүйл юм. 1636 -1691 он хүртэлхи монголчуудын түүхийг Манж Чин улсын түүхэнд шууд холбогдуулах нь улс үндэстний эрх ашигт хэрхэн нийцэх бэ? гэдгийг сайтар бодох хэрэгтэй болно.

Хоёрдугаарт. Монгол улсын түүх (XIV зууны II хагасаас XVII зууны II хагас) гэж үечилдэг. Манжийн хаан Долоннуурт ирж (1691он) Халх монгол манжид даган орсныг илтгэх чуулган чуулж², дараа онд нь (1692) Халхын ноёдод “хошуу захирах тамга” олгосноор³ “Халхчууд...50 гаруй жил тусгаар тогтнолоо хадгалж байгаад манжид эзлэгдсэн”⁴, “Халхын хаант улс” оршиж байсан нь “Монголын төр улсын уламжлал тасраагүй”⁵ Монгол улсын төв манай нутгаар төвлөн, Чин улстай зэрэгцэн бие даасан тусгаар улс болохоо илтгэн, төр улс оршин буйн үндсэн шинж эртний уламжлалт Чингис эзний удмын Алтан урагт хаант төрөө төвхнүүлж байсан гэсэн санааг сурвалж хэрэглэгдхүүн болон судалгааны зохиолуудад дурьсан байдаг. Хубилай хаанаас хойшхи төр-шашин хоёр ёсыг эрхэм болгон хагас зуун жил дотоод, гадаад бодлого явуулж ирсэн нь эш баримтаар тогтоогдож байна. Шашин төрийг хослон барьсан Богд хаант төр ёс уламжлан, XX зууны эхэнд бидний монголчууд тусгаар тогтнолоо тунхаглан, эдүгээ

¹ Дэй Хуни, Буян. Умард Юаны түүх. ӨМСХХ.,1991, Дарийжав. Мин улсын үеийн говийн өмнөд хэсгийн монголчуудын түүхийн судалгаа. Бээжин.,1997, Дундад улсын монгол судлалын тойм. ЛҮХХ.,2002, Жамбадорж. Болортоль. Хөххот.,1994, Ломи.Монгол боржигид овгийн түүх. Хөх хот.,1989, Лувсанданзан. Алтановч. УБ.,1970, Лиү Жин Сүэ. Монголын хураангуй түүх. Хөх хот.,1998, Монгол улсын түүх.гугтаар боть УБ.,2003

² Биеэр дайлж өрнө умрын газрыг түвшитгэн тогтоосон бодлогын бичиг. ӨМСХХ.,1992, тал. 157

³ Биеэр дайлж өрнө умрын газрыг түвшитгэн тогтоосон бодлогын бичиг. ӨМСХХ.,1992, тал. 184

⁴ БНМАУ-ын түүх. II боть. УБ.,1968, тал. 93

⁵ Д.Гонгор. Халхын үүсэл ба Халхын хаант улс (XIV-XVII зуун) түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг горилсон бүтээл УБ.,1967 он, Ли Бао-Вэнь. Дайчин улс ба Монголын Халхын хаант улс 1655 онд (“Монголын түүхэнд холбогдох архивын баримтын судалгааны өнөөгийн байдал, цаашдын зорилт” олон улсын бага хурал) Токио., 2003, тал. 157

бүрэн эрхэт Монгол улс оршин буйн үндэс болсон тул манай түүх судлалд энэ үеийг баримталдаг.

Гуравдугаарт. Дээрхи бүхнээс улбаалан 1690-ээд оноос Монголын төрийн төв болсон Халх монгол, манжийн захиргааг хүлээх болсноос хойш 1691-1758 он хүртэл жар гаруй жил монголчуудын нэг хэсэг-Ойрад монголчуудын түүхийг хэрхэн авч үзэх вэ? гэсэн асуудал зүй ёсоор тавигдана. 1630-аад онд хүчирхэг хаант төрөө тунхаглан, монголчуудын төдийгүй бүс нутгийн түүхэнд томоохон үүрэг гүйцэтгэж, Монгол улсын төрийг улбаалан, тусгаар тогтнолыг эрхэмлэн хамгаалж амжилттай гадаад, дотоод бодлого явуулж ирсэн билээ. Тусгаар тогтнолын асуудал, төрийн бодлогын үндэс залгамж шинжтэй болохоор энэ үеийг *Монгол улсын түүх (XIV зууны II хагасаас XVIII зууны 50-иад он)* гэж авч үзэж болно. Энэ санаа хэдийгээр шууд биш ч гэсэн судлаачдын зохиол бүтээлд олонтоо тусгагдаж, "...1636 онд Өмнөд монголын хаант улс манжид эзлэгдэн, 1691 онд Халх манжийн эрхшээлд орсны дараа бүх монгол угсаатны дотроос гагцхүү Баруун монголын Зүүнгарын хаант улс тусгаар тогтнолоо хадгалан үлдэж байжээ... Монголчуудын дотроос тусгаар тогтнолоо ганцаар хадгалж үлдсэн сүүлчийн улс"⁶, "Манжийн түрэмгийллийн уршгаар өвөр монголын байдал ийм болж...монголын баруун хэсэг болох Ойрад, умард хэсэг болох Ар халх тус тусдаа тусгаардуу боловч Монголын тусгаар тогтнолыг хадгалсаар байв"⁷, "баруун зүүн хоёр монгол нэгэн улсын хүрээнд...холбооны (федерацийн) улсын дүр төрхийг санагдуулна"⁸. Зүүнгарын хаант улс XVIII зууны дунд үе хүртэл...манжийн эсрэг тэмцэж байгаад...эзлэгджээ", "История Джунгарского ханства...является неотъемлемой частью общей истории Монголии"⁹, "Манж нар Бээжинг эзлэн авч ноёрхон суусан нь 1644 он боловч бүх Монголыг бүрэн эзлэн автал дахиад нэг зуун жил гаруй хугацаа шаардагджээ"¹⁰ гэж тус тус тэмдэглэж ирсэн. Энэхүү олон янзын ойлголт, үечлэл зэрэгцэн оршсоор байгаа нь түүхчид монголын түүхийн үечлэлийн асуудлаар нэгдмэл үзэл баримтлалд хүрч чадаагүйтэй холбоотой. Монгол улсын түүхийн ерөнхий үечлэлийн асуудлыг эргэн харах, монгол үндэстний эрх ашгийг дээдлэх үүднээс аливаа асуудлыг эдүгээчлэх хандлагаас аль болох зайлсхийн нэгдмэл байр суурь баримтлах шаардлагатай байна.

Нөгөө талаар уламжлалт түүх бичлэг дэх Хятадын түүх бичлэгийн хүрээнээс бүрэн ангижирч чадахгүй байгаатай ч холбоотой. Хятадад хорин таван төр (Династ) тогтсоны зарим нь харь үндэстний төр бөгөөд хятадын ард түмний өөрийн төр улсыг дээдлэх язгуур эрх ашгийн үүднээс тэдгээр харь улсын төрийг өөрийн түүхийн бүрэлдхүүнд багтаан бичиж ирсэн нь уламжлал болон тогтсон. Бид энэ асуудалд нухацтай хариулт өгөх ёстой. Дэлхийн улс орны түүхийг ажиглахад өөрийн улс төрийн тусгаар тогтнол алдагдсан үеийг хамгийн эмгэнэлт үе хэмээн үздэгчлэн улс төрийн дотоодын зөрчил тэмцлийн улмаас тусгаар тогтнолоо алдсан, үндэстний хувьд хуваагдан, ертөнцийн хөгжил дэвшлээс хол хоцроход хүргэсэн Манжийн ноёрхлын он жилүүдийг Монголчуудын хүчирхэгжилтийн зуун - Их Монгол улс, Эзэнт гүрний үе, өнөөгийн хөгжин дэвшсэн XX, XXI зуунтай адилтган түүхэн үечлэлийн нэгэн шугаман дээр тавьж үзэж болох уу? гэдгийг эргэж харах хэрэгтэй болж байна. Иймээс Монгол улс үндэстнийхээ түүхийг туурвихдаа, судлахдаа, сонирхохдоо өөрөөрөө төвлөн, өөрийн улс үндэстний эрх ашгийн үүднээс хандах нь амин чухал учир *XIV зууны II хагасаас XX зууны эхэн хүртэл Монголын түүхийг нэгэн бүхэл үе* болохыг онцлоод, дотор нь:

⁶ Н.Ишжамц. Монголын ард түмний 1755-1758 оны тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл. УБ.,1962, тал. 15

⁷ Л.Жамсран. Монголын түүхийн өгүүлүүд. I. УБ.,2000, тал.18

⁸ М. Санждорж. Монгол төрийн түүхээс. УБ.,1998

⁹ Грумм-ГржимайлоГ.Е. Западная Монголия Урянхайский край. Том. II. Л.,1926, с.606-682, Ш.Нацагдорж Монголын феодализмын үндсэн замнал. УБ.,1978, тал. 133, М.Санждорж. Монголын төрийн түүхээс. (XIII-XIX зуун) УБ.,1991, тал.79-99, И.Я.Златкин. История Джунгарского ханства. М.,1983, с. 304

¹⁰ Owen Lattimore. Нүүдэлчид ба хувьсгалчид. УБ.,1994, тал. 94

I. МОНГОЛЫН ТҮҮХИЙН ДУНДАД ҮЕИЙН АСУУДАЛ

Нэг талаас XIV зууны II хагасаас XVIII зууны дунд үе (1368-1758 он) хүртэл монгол оронд улс төрийн тэмцэл, задрал бутрал зонхилох болж үндэсний тусгаар тогтнол хэврэгшсэн тул бүхэлдээ улс орны эв нэгдлийг хангах, тусгаар тогтнолоо хамгаалахын төлөө тэмцлийн жилүүдийн түүх байсан.

Нөгөө талаас XVII зууны эхнээс манжийн түрэмгийлэл эхлэн, Монгол улсын зах хязгаараас нь өөртөө нэгтгэснээр, XVIII зууны дунд үеэс XX зууны эхэн хүртэл Монгол улс тусгаар байдлаа алдан Чин гүрний зах хязгаар, хараат орон болж хувирсан гэж *хоёр шат болгон үечилж* үзэж болох юм.

Abstract: To the problem of periodisation of Mongolian History

Brief content of the sentence: Since it is not appropriate in this sentence to compare various interpretations of a certain stage of Mongolian history, and name them depending on any new specific formulas or political events, it is proposed to understand it by referring to the historic general periodisation and with time limitation.

Ном зүй

1. БНМАУ-ын түүх .УБ.,1966
2. Грумм-Гржимайло Г.Е. Западная Монголия Урянхайский край .том.,II .Л.,1926
3. Дай Хуни, Буян. Умард Юаний түүх. Хайлаар.,1991
4. Далай Ч. Монголын түүх. (гутгаар дэвтэр)УБ.,1992
5. Дарийжав. Мин улсын үеийн говийн өмнөд хэсгийн монголчуудын түүхийн судалгаа Бээжин .,1997
6. Дундад улсын монгол судлалын тойм. ЛҮХХ., 2002
7. Златкин И.Я. История Джунгарского ханства. М.,1983
8. Лиү Жин Сүэ. Монголын хураангуй түүх. Хөх хот., 1998
9. Монгол улсын түүх. Таван боть зохиол. Гутгаар боть. УБ., 2003
10. Нацагдорж Ш. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978
11. Owen Lattimore. Нүүдэлчид ба хувьсгалчид. УБ.,1994, тал. 94
12. Санждорж М.Монголын төрийн түүхээс.(XIII-XIX зуун) УБ., 1991
13. Энхцэцэг Д. “Улсын нэрийн тухай.” МУИС. Түүх . сэтгүүл IV. УБ., 2005